



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 319

Улаанбаатар хот

Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Мөнх даатгал” ХХК-ийн “Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал”-ын бүтээгдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, “Ипотекийн барьцаа хөрөнгийн даатгал”-ын бүтээгдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус бүртгэсүгэй.

2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “...Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Мөнх даатгал” ХХК /Т.Оюунгэрэл/-д үүрэг болгосугай.

3. Тус бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Мөнх даатгал” ХХК /Т.Оюунгэрэл/, актуарч /Б.Баярмагнай/-д тус тус анхааруулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН



Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 11 сарын 22 өдрийн
319-р тогтоолын хавсралт 2

Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл /Ипотекийн барьцаа хөрөнгийн даатгал/

| | | |
|-----|--|--|
| 1. | Даатгалын компанийн нэр: | “Мөнх даатгал” ХХК |
| 2. | Даатгалын бүтээгдэхүүний нэр: | Ипотекийн барьцаа хөрөнгийн даатгал |
| 3. | Хамаарах даатгалын хэлбэр: | Хөрөнгийн даатгал |
| 4. | Даатгалын зүйл | Даатгалын зүйл нь ипотекийн зээлээр худалдан авч буй, үндсэн барьцаа болох орон сууц |
| 5. | Даатгалын эрсдэл | -Галын эрсдэл (гал түймэр, дэлбэрэлт); -Сантехникийн эрсдэл; -Байгалийн эрсдэл (Газар хөдлөлтийн эрсдэл хамаарахгүй); -Цахилгаан, эрчим хүчний эрсдэл; -Гуравдагч этгээдээс учруулсан санаатай болон санамсаргүй үйлдэл. |
| 6. | Даатгалын гэрээний хугацаа | Даатгуулагч даатгагч харилцан тохиролцоно |
| 7. | Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо | 11 бүлэг, 128 заалт |
| 8. | Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр: | Гүйцэтгэх захирлын 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 025 тоот шийдвэр |
| 9. | Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч: | Б.Баярмагнай |
| 10. | Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан: | Бизнес хөгжлийн газрын захирал Ч.Мөнхдөл, үйл ажиллагааны газрын захирал Б.Наранбаатар |



Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл /Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал/

| | | |
|-----|--|---|
| 1. | Даатгалын компанийн нэр: | “Мөнх даатгал” ХХК |
| 2. | Даатгалын бүтээгдэхүүний нэр: | Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал |
| 3. | Хамаарах даатгалын хэлбэр: | Гэнэтийн осол, эмчилгээний даатгал |
| 4. | Даатгалын зүйл | Даатгуулагчийн амь нас, эрүүл мэндтэй холбоотой ашиг сонирхол |
| 5. | Даатгалын эрсдэл | -Гэнэтийн ослын улмаас даатгуулагч нас барах -Гэнэтийн ослын улмаас даатгуулагч хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдах |
| 6. | Даатгалын гэрээний хугацаа | Даатгуулагч даатгагч харилцан тохиролцоно |
| 7. | Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо | 11 бүлэг, 116 заалт |
| 8. | Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр: | Гүйцэтгэх захирлын 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 025 тоот шийдвэр |
| 9. | Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч: | Б.Баярмагнай |
| 10. | Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан: | Бизнес хөгжлийн газрын захирал Ч.Мөнхдөл, үйл ажиллагааны газрын захирал Б.Наранбаатар |